

**“ МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ” ОНӨТҮГ-ЫН
2023-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

УЛААНБААТАР ХОТ 2023 ОН

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	5
ХОЁР.МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ.....	6
ГУРАВ. АЛСЫН ХАРАА.....	14
ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО.....	14
ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ.....	15
ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО.....	18
ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ ТҮВШИН, ЗОРИЛТОТ ТҮВШИН	19
НАЙМ.СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА БҮТЦИЙН УЯЛДАА	22
ЕС.“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ-ЫН СТРАТЕГИЙН ЗУРАГЛАЛ.....	24

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ.....	6
ХҮСНЭГТ 2. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОГЧ ТАЛУУД.....	10
ХҮСНЭГТ 3. ХОЛБОГДОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦОО	11
ХҮСНЭГТ 4. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ХУВИАР.....	12
ХҮСНЭГТ 5. БАЙГУУЛЛАГЫН ГАДААД, ДОТООД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН (SWOT ШИНЖИЛГЭЭ).....	16
ХҮСНЭГТ 6. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО	19
ХҮСНЭГТ 7. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ ТҮВШИН, ЗОРИЛТОТ ТҮВШИН	19
ХҮСНЭГТ 8. БҮТЭЦ, ОРОН ТОО.....	23
ХҮСНЭГТ 9. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА.....	25
ХҮСНЭГТ 10. “МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ-ЫН СТРАТЕГИЙН ЗУРАГЛАЛ.....	25

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Албан хаагчдын албан тушаал хүйс.....	22
Зураг 2. Албан хаагчдын нас.....	22
Зураг 3. Байгууллагын бүтэц.....	23

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Төрийн албаны тухай хууль (2017 оны шинэчилсэн найруулга)-ийн 53 дугаар зүйлийн 53.1-д зааснаар “ Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна ” гэж хуульчилсан.

Энэ хүрээнд Засгийн газрын 2020 оны “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам батлах тухай” 216 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар “ Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал ”-ыг шинэчлэн баталсан.

“ Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам ”-ын дагуу Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байдлаар Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын стратеги төлөвлөгөөг дөрвөн жилийн хугацаатайгаар боловсруулахаар тусгасан байна.

Иймд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09 дүгээр тогтоолоор батлагдсан Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/10 дугаар тогтоолоор батлагдсан “ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/667 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг үндэслэн “ Монгол наадам цогцолбор ” ОНӨТҮГ-ын 2023-2024 оны Стратеги төлөвлөгөөг боловсруулах шаардлага үүсэж байна.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 99 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “ Монгол наадам цогцолбор “ ОНӨТҮГ-ын дүрмийн хэрэгжилтийг хангах зорилгоор энэхүү стратеги төлөвлөгөөг боловсруулав.

ХОЁР . МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандат нь төрийн байгууллагын хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээтэй холбоотой байдаг.

Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал” -д тусгаснаар “ Чиг үүрэг гэдэг нь төрийн байгууллагад хуулиар тогтоосон эрх мэдлийн хүрээнд тодорхой үр дүнд хүрэх зорилгоор хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тодорхой чиглэл юм ” гэж тодорхойлсон.

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд мандатын буюу чиг үүргийн шинжилгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны “ Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам батлах тухай ” 216 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг мөрдлөг болгов.

“Монгол наадам цогцолбор “ ОНӨТҮГ-ын мандатын шинжилгээг дараах алхмуудын хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Алхам 1. “Монгол наадам цогцолбор “ ОНӨТҮГ-ын чиг үүргийг тодорхойлох

Хүснэгт 1. “Монгол наадам цогцолбор “ ОНӨТҮГ-ын чиг үүрэг

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо-6		1. Үндэсний их баяр наадмын тухай 2. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай 3.Төсвийн тухай 4. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 5. Архив албан хэрэг хөтлөлтийн тухай 6.Автозамын тухай
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо-2	1. Үндэсний их баяр наадмын тухай 2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо 4	1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 2.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай 3.Төсвийн тухай
Ерөнхий чиг үүрэг-1 Хүй долоон худгийн хурдан морины барианы газар орчим хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажлуудын арчлалт, хамгаалалтыг хариуцах		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах	1.Зам талбай, авто зогсоолын бүрэн бүтэн байдлыг хангах	Тохижилт үйлчилгээний алба
	2.Инженерийн шугам сүлжээ, техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, ашиглалтыг хариуцан ажиллах	Тохижилт үйлчилгээний алба
	3.Барилга, байгууламжийг засварлах, шинэчлэх	Тохижилт үйлчилгээний алба

	4.Хөрс, орчны бохирдлоос сэргийлж, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийх	Тохижилт үйлчилгээний алба
	5.Эд хөрөнгийн арчлалт, хамгаалалтыг хариуцах	Санхүү, хөрөнгө оруулалтын алба, Тохижилт үйлчилгээний алба
Ерөнхий чиг үүрэг-2. Улс, Нийслэлээс зохион байгуулдаг томоохон баяр наадмын бэлтгэл ажлыг хангах		
ҮЧҮ-1:Төрийн ёслол , Үндэсний их баяр наадам, “Хүрээ цам”шашин соёлын наадам, Үндэсний спортын их наадмын бэлтгэл ажлыг хангаж, үйлчилгээг үзүүлэх	1.Хурдан морь барилцан газарт тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэх	ҮИБНЗБХ-ны Тохижилт, худалдаа үйлчилгээний салбар хороо, Тохижилт үйлчилгээний алба
	2. Нийтийн бие засах газруудын хэвийн ажиллагааг хангах	ҮИБНЗБХ-ны Тохижилт, худалдаа үйлчилгээний салбар хороо, Тохижилт үйлчилгээний алба
	3. Цэвэр ус хангамж, бохир усыг татан зайлуулах ажлыг зохион байгуулах	ҮИБНЗБХ-ны Тохижилт, худалдаа үйлчилгээний салбар хороо, Тохижилт үйлчилгээний алба
	4. Наадамчдын ая тухтай байдлыг хангаж, тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэх	ҮИБНЗБХ-ны Тохижилт, худалдаа үйлчилгээний салбар хороо, Тохижилт үйлчилгээний алба
	5. Худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хэвийн үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлэх	ҮИБНЗБХ-ны Тохижилт, худалдаа үйлчилгээний салбар хороо,Маркетинг хамтын ажиллагааны алба
	6. Гар урлал, соёлын барааны худалдаа, хөдөлгөөнт тоглоомын үйл ажиллагаа явуулах иргэн, аж ахуйн нэгж байгууллагад зөвшөөрөл олгож, хэвийн үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлэх	ҮИБНЗБХ-ны Тохижилт, худалдаа үйлчилгээний салбар хороо, Маркетинг хамтын ажиллагааны алба
Ерөнхий чиг үүрэг 3. Монгол наадам цогцолборын хүрээнд хийгдсэн бүтээн байгуулалт, тохижилтын ажлыг гүйцэтгэх, хүлээн авах, түүнтэй холбогдон үүсэх, эрх үүрэг, хариуцлагыг хүлээх		

ҮЧҮ:1 “Монгол наадам үндэсний спорт цогцолбор”-ын хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах	1.Бүтээн байгуулалтын ажлуудын зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах ажлын саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлэх	Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газар, Хот байгуулалтын хүрээлэн, Захиргаа удирдлагын алба, Маркетинг хамтын ажиллагааны алба
	2. Улс, Нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын жагсаалтад оруулах санал хүргүүлэх	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар, Захиргаа удирдлагын алба Маркетинг хамтын ажиллагааны алба
	3.Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийгдэх бүтээн байгуулалтын ажилд гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нарыг татан оролцуулах саналыг хүргүүлэх	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар, Захиргаа удирдлагын алба Маркетинг хамтын ажиллагааны алба
Ерөнхий чиг үүрэг 4. Соёл урлаг, аялал жуулчлалын эвент арга хэмжээ, бүтээгдэхүүн үйлчилгээг дангаар болон хамтран зохион байгуулах		
ҮЧҮ-1: Иргэд олон нийтийг ая тухтай амрах, чөлөөт цагаа таатай өнгөрүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх.	1.Гадаадын болон бүс нутгийнхаа цогцолбор, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай бүх түвшинд хамтарсан сургалт, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх.	Маркетинг хамтын ажиллагааны алба
	2.Гадаад, дотоодын холбогдох байгууллагуудтай зохих журмын харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх.	Маркетинг хамтын ажиллагааны алба, Санхүү, хөрөнгө оруулалтын алба
	3.Олон нийтийн соёл спортын арга хэмжээг хэвийн явуулах, цахилгаан эрчим хүч, усан хангамжийн хэвийн ажиллагаагаар хангах, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол үзүүлэх, бусад	ЗАА,Маркетинг хамтын ажиллагааны алба, Тохижилт үйлчилгээний алба

	ногоон байгууламж, тохижилт үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллах талаар холбогдох байгууллагуудтай ажлын уялдаа холбоотой ажиллах	
	4.Төрөл бүрийн эвент арга хэмжээг дангаар болон хамтран зохион байгуулах	Маркетинг хамтын ажиллагааны алба
Ерөнхий чиг үүрэг 5.Бүтээн байгуулагдсан нийтийн зориулалттай эд хөрөнгийг түрээслэх, орлого бүрдүүлэх		
ҮЧҮ-1:Санхүү, эдийн засгийн бодлогын хүрээнд Орлогын бүрдүүлэлт, түүний эх үүсвэрийн төрөл зүйлийг өргөжүүлэхэд анхаарч, орлогын төлөвлөгөөг биелэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээ авах.	1.Цогцолборын чадавхыг бэхжүүлэх, материаллаг баазыг хамгаалах, түүнийг бэхжүүлэх, барилга байгууламжийг засварлах, шинэчлэх, ашиг орлогыг нэмэгдүүлэх бизнесийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах	Санхүү хөрөнгө оруулалтын алба, Маркетинг хамтын ажиллагааны алба
	2. Хамтын ажиллагааг өргөжүүлж, орлого бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр Төрийн болон ТББ, иргэдтэй хамтран ажиллах	Захиргаа удирдлагын алба, Маркетинг хамтын ажиллагааны алба
	1.Нийслэлийн өмчит барилга байгууламж, авто зам, талбай, тоног төхөөрөмж, эд хогшлыг түрээсээр ашиглуулах, төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх	Үндэсний спортын холбоод, ААНБ, иргэд, Маркетинг хамтын ажиллагааны алба
ҮЧҮ-6: Байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэх, сургаж хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах замаар гүйцэтгэлд суурилсан бүтээлч, чадварлаг, тогтвор суурьшилтай хүний нөөцийг бий болгож байгууллагын тогтвортой хөгжлийг хангахад чиглэнэ.	1.Албан хаагчдын нийгмийн баталгаа, ажлын байрны орчныг сайжруулах;	Захиргаа удирдлагын алба
	2.Удирдлагын манлайлал дор хүний хөгжлийн бодлогыг боловсруулж, хүний нөөцийн нэгдсэн мэдээллийн систем бүрдүүлж ажиллана.	Захиргаа удирдлагын алба

Хүснэгт 3. Холбогдогч талуудын оролцоо

Холбогдогч талууд	Оролцоо					
	Мэдээллэх	Санал өгөх	Хамтран ажиллах	Шийдвэр гаргах	Хяналт тавих	Бусад
Улсын Их Хурал		✓		✓		
Засгийн газар		✓		✓		
Яам		✓		✓		
ҮИБН-ын ТХҮ-ий салбар хороо	✓	✓	✓	✓	✓	
Засгийн газрын агентлаг	✓	✓	✓			
Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	✓	✓		✓		
Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	✓	✓	✓	✓	✓	✓
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	✓	✓	✓	✓	✓	✓
Нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагууд	✓	✓	✓			
Дүүргийн Засаг дарга нар	✓	✓	✓			
Үндэсний спортын холбоод	✓	✓	✓			
Биеийн тамир спортын байгууллагууд	✓	✓	✓			
Аялал жуулчлалын байгууллагууд	✓	✓	✓			
Хэвлэл мэдээллийн байгууллага	✓	✓	✓			
Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид	✓	✓	✓			
Сургалт, судалгааны байгууллага	✓	✓	✓			
Аж ахуйн нэгж байгууллага иргэн	✓	✓	✓			

Алхам 3.Байгууллагын дүрмээр хүлээсэн биелэлтийн тайланг судлах

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн “ Монгол наадам цогцолбор” орон нутгийн өмчит , төсөвт үйлдвэрийн газрыг байгуулах тухай 99 дүгээр тогтоолын хавсралтаар “ Монгол наадам цогцолбор “ ОНӨТҮГ-ын дүрэм батлагдсан .

Хүснэгт 4.Байгууллагын чиг үүргийн хэрэгжилт хувиар

дд	Дүрмээр хүлээсэн үүрэг	Заалтын дугаар	Үүргийн биелэлт	Биелэлтийн хувь
1	Газрын зорилго нь Монгол наадам цогцолборын хүрээнд хийгдсэн бүтээн байгуулалт, тохижилтын ажлыг хүлээн авах, түүнтэй холбогдон үүсэх эрх, үүрэг, хариуцлагыг хүлээж олон нийтийн арга хэмжээ, баяр наадам зохион байгуулах, зам, талбай, авто зогсоол , түүний эд хөрөнгө, инженерийн шугам сүлжээ, техник, тоног төхөөрөмж, тохижилтын бүрэн бүтэн байдал, ашиглалтыг хариуцан ажиллахад оршино.	3.1	Монгол наадам цогцолборын хүрээнд бүтээн байгуулалтын ажлууд хийгдээгүй. Улсын их баяр наадмын бэлтгэл ажлын хүрээнд Нийтийн бие засах газруудын засварт 18,0 сая, морь барианы газрын орчмын засвар, тохижилт 18,5 сая, сэтгүүлчийн индрийн шат шинээр хийх 10,0 сая, машин техникийн засвар 10,3 сая, будгийн ажил 9,7 сая, худгийн насос солих 2,0 сая нийт 68,5 төгрөгийн ажлуудыг өөрийн ажилтнуудын хүчээр чанартай хийж гүйцэтгэж, комисст хүлээлгэн өгсөн.	100
2	Газар нь өөрийн хүчин чадлыг бүрэн ашиглан төрийн ёслол , Улсын баяр наадам, тив улсын чанартай спортын болон сонирхогчдын тэмцээн, уралдаан, спортын төрөл бүрийн арга хэмжээ, шоу болон цэнгээнт арга хэмжээ, гадаад болон дотоод худалдаа, нийтийн амралт, зугаалга, үйлчилгээ зэрэг арга хэмжээнд нийтийн эзэмшлийн барилга байгууламж, автозам, талбай, тоног төхөөрөмжийг түрээслэх, төлбөртэй үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа явуулна .	3.2	Хүй долоон худагт нийт 11 арга хэмжээ зохион байгуулагдахад байгууллагын эд хөрөнгийг түрээслэх , газрыг төлбөртэй ашиглуулах , бусад арга хэмжээнд эд хөрөнгө түрээслэх зэргээр орлого бүрдүүлж нийт 85,0 сая төгрөгийн төсвийн орлого бүрдүүлэхээс 142,0 сая төгрөгийн орлого бүрдүүлж орлого бүрдүүлэлтийн төлөвлөгөөг 164,7 %-иар биелүүлсэн.	100

3	Газар нь гадаад дотоодын холбогдох байгууллагуудтай зохих журмын дагуу харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх, түүнчлэн хуулийн байгууллагад нэхэмжлэгч, хариуцагчаар оролцоно.	3.3	Газрын хэмжээнд хийгдэх гэрээнүүдийн загварыг шинэчилж эхний Ажил гүйцэтгэх гэрээ -23, Газар ашиглуулах гэрээ-6, Түрээсийн гэрээ-19, Хамтран ажиллах гэрээ -2, Худалдах, худалдан авах гэрээ-12, Худалдаа, үйлчилгээ үзүүлэх гэрээ-51, Хөлсөөр ажиллуулах гэрээ-69, Утас интернэт , ашиглах гэрээ-3 нийт 185 гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан.	100
4	Газар нь цогцолборын чадавхыг бэхжүүлэх, материаллаг баазыг хамгаалах, түүнийг бэхжүүлэх, барилга байгууламжийг засварлах, шинэчлэх, ашиг орлогыг нэмэгдүүлэх бизнесийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллана.	3.4	Газрын 2022 оны бизнес төлөвлөгөөг боловсруулан батлуулж мөрдөж хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан.	100
5	Газар нь олон нийтийн арга хэмжээ, баяр наадмын үйл ажиллагааг хэвийн явуулах, цахилгаан эрчим хүч, усан хангамжийн хэвийн ажиллагаагаар хангах, цэвэрлэгээ, үйлчилгээг тогтмол үзүүлэх, бусад ногоон байгууламж, тохижилт, үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллах талаар холбогдох байгууллагуудтай ажлын уялдаа холбоотой ажиллана.	3.5	Газар нь Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ХК-тай хамтран ажиллаж Улсын их баяр наадам, Хүрээ цам-Даншиг наадам зэрэг томоохон арга хэмжээнүүдэд цахилгаан эрчим хүчний хэвийн ажиллагааг хангаж ажилласан. Ус сувгийн Удирдах газартай хамтран цэвэр усны худгуудын хэвийн ажиллагааг хангаж ажиллав. Цэвэр ус тээвэрлэлт, бохир усыг татан зайлуулах ажлыг гэрээний үндсэн дээр тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлсэн. Наадмын бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн тохижилт, засвар, үйлчилгээний ажлуудыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны ажил хүлээж авах комисст хүлээлгэн өгсөн. Чанар, стандартын зөрчил гараагүй.	100
6	Нийслэлийн өмчит барилга байгууламж, автозам,	3.6	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын	70

талбай, тоног төхөөрөмж, эд хогшлыг ашиглуулах, төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний хөлс, үнэ тарифыг зах зээлийн судалгаанд үндэслэн бизнес төлөвлөгөөтэй уялдуулан жил бүр шинэчлүүлж, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж мөрдөнө.		хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөж буй асуудлын саналд “Үнэ тарифыг шинэчлүүлэх” саналыг тусгуулахаар 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 13 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үнэ тариф шинэчлүүлэх саналд 7 төрлийн үйлчилгээнд 68 үнэ тарифыг шинэчлүүлэхээр төсөл боловсруулсан. Одоо байдлаар хэлэлцэгдэж шийдвэрлэгдээгүй байна.	
Биелэлтийн дундаж хувь			95,0

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Алсын хараа нь байгууллагын ирээдүйн төлөвийг илэрхийлсэн, хөгжлийн чиг баримжааг тодорхойлсон үр дүн юм.

Алсын хараа нь амжилт дэвшилд хөтлөх уриа дуудлага бөгөөд “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын үйл ажиллагаа бүхэлдээ алсын хараанд чиглэнэ.

“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ-ЫН АЛСЫН ХАРАА

МОНГОЛ УЛСАД ТИВ, ДЭЛХИЙН ЧАНАРТАЙ СПОРТЫН ТЭМЦЭЭН, УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ОЛОН УЛСЫН ЖИШИГ, СТАНДАРТАД НИЙЦСЭН СОЁЛ, СПОРТ, АМРАЛТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР БОЛНО.

УРИА: МОНГОЛ НААДАМ-ДЭЛХИЙН ӨВ

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Эрхэм зорилго нь байгууллагын одоо ба ирээдүйн үйл ажиллагааны талаарх үнэт зүйл, хөгжлийн үзэл баримтлал, оршин тогтнох учир шалтгааныг илэрхийлнэ.

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын эрхэм зорилгыг байгууллагын дүрмээр хүлээсэн үүрэгт тулгуурлан томьёолсон.

Ингэхдээ бид юу хийдэг вэ, хэнд зориулж үүнийг хийдэг вэ, яагаад үүнийг хийдэг вэ гэсэн гурван асуултыг чиг баримжаа болгов.

“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ-ЫН ЭРХЭМ ЗОРИЛГО

НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШИЛ, МОНГОЛЧУУДЫН УЛАМЖЛАЛТ ЁС ЗАНШИЛ, ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫГ СУРТАЛЧЛАХ, СПОРТЫН УРАЛДААН ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ИРГЭД ОЛОН НИЙТИЙГ АЯ ТУХТАЙ АМРАХ, ЧӨЛӨӨТ ЦАГАА ТААТАЙ ӨНГӨРҮҮЛЭХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ

ҮНЭТ ЗҮЙЛ

“Монгол наадам цогцолбор “ ОНӨТҮГ нь үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан зарчмуудыг баримтлах бөгөөд энэхүү стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараах зүйлсийг эрхэмлэнэ.

- Монгол ахуй ба Монгол наадам
- Уламжлалт зан заншил
- Эко хөгжил болон ногоон бүс
- Чанар, ил тод хариуцлагатай байдал
- Шинэ бүтээлч сэтгэлгээ

ТАВ.ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Монгол наадам цогцолборын өнөөгийн байдлын үнэлгээ, хүрсэн түвшнийг тогтоохын тулд байгууллагын үйл ажиллагааг дүгнэх аргачлалыг ашиглан тодорхойлсны зэрэгцээ сүүлийн 4 жилийн хөгжлийн үзүүлэлтүүдийн судалгааг гаргаж, SWOT, PEST шинжилгээг хийв. Цогцолборын хүрэхээр төлөвлөж байгаа зорилго, хэрэгжүүлэх стратеги, үр дүнгийн үзүүлэлтийг SWOT шинжилгээнд ашиглан тодорхойлов.

Гадаад хүчин зүйл: байгаль орчин, институц (төрийн бодлого, олон улсын болон, дотоодын хууль, журам, тогтсон заншил), дотоод, гадаад зах зээл, өрсөлдөгч, хөдөлмөрийн зах зээл, банк санхүүгийн систем зэрэг цогцолборын үйл хэрэгт нөлөөлөх гадаад хүчин зүйлсийн эерэг, сөрөг нөлөө

Дотоод хүчин зүйл: хөрөнгө, материал, ажиллах хүч, технологи, инновац, чадвар чадавх, менежмент зэрэг цогцолборын дотоод боломжийн эерэг сөрөг талыг сайтар нягтлан одоогийн түвшин, цаашдын хөгжлийн хандлага

Гадаад, дотоод хүчин зүйлсийг нягтлан тодорхойлсны цогцолборын зорилгыг хэрэгжүүлэх стратегийг доорх байдлаар тодорхойлно.

SO- шийдвэр: цогцолборын давуу талд тулгуурлан гадаад орчны таатай боломжийг дээд зэргээр ашиглах (**богино хугацааны стратеги**),

WO- шийдвэр: цогцолборын сул талыг сайжруулан гадаад орчны таатай боломжийг дээд зэргээр ашиглах (**дунд хугацааны стратеги**),

ST-шийдвэр: цогцолборын давуу талд тулгуурлан гадаад орчны таагүй нөхцөлийн сөрөг нөлөөг бууруулах (**дунд хугацааны стратеги**),

WT- шийдвэр: гадаад орчны таагүй нөхцөлд цогцолборын сул талаа сайжруулах замаар гарах сөрөг үр дагаврыг аль болох багасгах (**урт хугацааны стратеги**)

Хүснэгт 5. Монгол наадам цогцолборын SWOT шинжилгээний матриц

Дотоод хүчин зүйлс	
Давуу тал (S)	Сул тал (W)
- Хотын ойролцоо том газар нутаг бүхий цогцолбор - Баяр наадам, спорт тэмцээн зохин байгуулах холбоод, байгууллагатай хамтран ажиллаж байгаа - Дугуйн зориулалтын зам талбайтай - Сүүдрэвч, амрах цэгүүдтэй - Материаллаг суурь бааз бэхжиж байгаа - Амарч тухлах үйлчилгээний гэр бааз ажиллаж байгаа	- Техник, технологийг байнга шинэчлэх шаардлагатай - Зуны улиралд ажиллах хүчин дутагдалтай - Ажилчдын мэдлэг мэдээллийг байнга дээшлүүлэх шаардлагатай - Гэр баазыг стандартад нийцсэн байдлаар тохижуулах шаардлагатай - Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа бага хийгддэг - Гадаад дотоодын жуулчдад зориулсан усанд орох газар хүндрэлтэй
Гадаад хүчин зүйлс	
Таатай нөхцөл (O)	Таагүй нөхцөл (T)
- Хүй долоон худагт хэрэгжиж буй баяр наадам, спорт арга хэмжээний тоог эрчимтэй нэмэгдүүлэх боломжтой - Гадаадын цогцолбортой хамтарсан сургалт, судалгааны хөтөлбөр хэрэгжүүлэх - Гадаадын хөрөнгө оруулалт татах чиглэлээр идэвхтэй ажиллаж байна - ҮИБН-ын хурдан морины уралдаан болдог - Олон төрлийн арга хэмжээ зохион байгуулахад тохиромжтой, газар нутаг харьцангуй том - Эрүүл агаартай - Спортын олон төрлийн холбоодтой хамтарч ажиллаж байгаа	- Бүтээгдэхүүн үйлчилгээг үнэлгээ тогтооход нэмэгдлийг хүлээн авах нийгмийн сэтгэл зүйн орчин бүрдээгүй - Хөрөнгө оруулалт нь ашиглалт, үйлчилгээний зардал өндөр - Улсын өмч хөрөнгийг хайрлан хамгаалах тал дээр нийт иргэдийн мэдлэгийн түвшин доогуур - Холбоодод санхүүжилт дутагдалтай байдаг - Улс, нийслэлийн шинж чанартай баяр наадмаар газар хуваарилалт, зохион байгуулалтыг дээд шатны удирдах байгууллагаас хийдэг - Хотоос зайдуу, нийтийн тээвэр үйлчилдэггүй - Салхи ихтэй, задгай, талархаг нутаг дэвсгэр тул зунаас бусад

	улиралд арга хэмжээ зохион байгуулахад хүндрэлтэй  Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн асуудлаар төрийн дээд шатны байгууллагуудтай харилцахад байгууллагын статус доогуур
--	--

Энэхүү SWOT шинжилгээнээс үзэхэд, Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын дотоод сул талаа багасгах, улмаар давуу тал, боломжоо ашиглан хүндрэл бэрхшээлийг даван туулах шаардлагатай байна.

PEST ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

1.Улс төр, хуулийн хүчин зүйл (P)

Монгол Улсын улс төр, нийгэм, эдийн засгийн байдал, эдийн засагт гарч буй хандлага болон уламжлал, ёс заншлаа дээдлэх, нийтийн эрүүлмэндийг хамгаалах, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чанартай үйлчилгээгээр хангах, нийгмийн орчин бүрдүүлэх талаар Засгийн газраас баримталж буй тууштай байр суурь, хүчин чармайлт, хүрсэн амжилт нийгэм, эдийн засаг, эрх зүйн таатай орчин болно.

Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийтийн биеийн тамир, спорт, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх тодорхой зорилтууд тусгагдсан.

Нийтийн биеийн тамир, спортын болон аялал жуулчлалын холбогдолтой хууль эрх зүйн баримт бичгүүд гарсан, зарим нь тодотгол, өөрчлөлт хийгдэж байгаа.

Аялал жуулчлал, спортын салбарт үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх шаардлагатай байгаа.

Аялал жуулчлал, спортын үйл ажиллагааг нээлттэй, ил тод, олон нийтийн оролцоонд тулгуурлан явуулах эрх зүйн орчинг тодорхой болгож, удирдлагын үндсэн зарчмын хэрэгжилтийг бодитой шуурхай болгохгүйгээр байгууллагын үйл ажиллагааны чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх боломж хязгаарлагдсаар байх болно.

Аялал жуулчлалын салбарт зах зээл хөгжсөн улс орнуудын нийтлэг жишиг, туршлагаас өөртөө зохих ёсоор шингээсэн төрийн бодлого, эрх зүйн орчин харьцангуй богино хугацаанд цоо шинээр бүрэлдэж, шинэтгэлийн бодлого өнөөдөр үргэлжилж байна.

Аялал жуулчлалын салбарын сурталчилгаа, сургалтын зохион байгуулалтыг олон улсын түвшинд гаргаж сурталчилж байна. Үүнд:Засгийн газраас ойрын 3 жилийг эдийн засгийг дэмжих жил болгон зарласан, ИТВ- ХБНГУ-д зохион байгуулагддаг олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол улс тогтмол оролцож байна.

Монголын говь нутаг Дэлхийн жуулчдын анхаарлыг татсан 10 үзмэр бүхий газар нутагт орсон.

Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх хууль, эрх зүйн үндэс бүрэлдэж байгаа боловч энэ нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нарыг татах хэмжээнд хүрээгүй байна.

2.Эдийн засгийн хүчин зүйл (E)

Аялал жуулчлал, спортын хөгжлийн асуудал нь төр, засаг, иргэд, төрийн бус байгууллагуудын бүх талын нэгдмэл эрх ашиг, байр суурийг хөндсөн асуудал тул түүнийг дэмжих, тавигдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд бүх талын оролцоо байх боломжтой.

МУ-ын нийгэм, эдийн засаг, хөгжлийн суурь бодлого, стратегид тулгуурласан аялал жуулчлалын урт хугацааны үндэсний төлөвлөгөө бий болсон нь бүх талын хамтын ажиллагааг нэгдмэл бодлогын дор зохицуулах, аялал жуулчлал гадаад хөрөнгө оруулалт, тусламжийг нэмэгдүүлэх, зээл, тусламжийг оновчтой, үрдүнтэйгээр ашиглах боломжийг бий болгоно.

Эдийн засгийн зарим гол үзүүлэлтүүд, нэг хүнд ногдох ДНБ нь өсөж байгаа нь иргэдийн орлогын хэмжээнд эергээр нөлөөлөх төлөвтэй байгаа нь дотоодын аялан жуулчлагчдын тоо нэмэгдэх нэгэн хөшүүрэг юм.

Байгууллагын жил бүрийн төлөвлөгөөнд тусгагддаг баяр наадмууд, оны хөрөнгө оруулалтууд нь орлогын тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлж байна.

Газар нутаг түүн дээр хийгдсэн хөрөнгө оруулалт боловсон бие засах газар, дугуйн зам, үйлчилгээний талбай зэрэг нь дотооддоо өрсөлдөгч багатай.

Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, эрүүл агаарт идэвхтэй амралтыг иргэн бүр дэмжих хандлага дээшилж байна.

Хөгжилтэй орнуудын түвшний хэмжээнд хүрэхүйц жилийн дөрвөн улиралд тасралтгүй үйл ажиллагаа явуулах орчныг бүрдүүлэх асуудлыг бие даан шийдвэрлэж чадахааргүй байна.

3.Нийгмийн хүчин зүйл (S)

Улсын тэргүүлэх салбар уул уурхай хөгжих чиглэлд уул уурхайн байгууллагууд ихсэж байгаагаас хүн ам цөөнтэй манай орны хувьд аялал жуулчлалын салбарын хөгжлийг удаашруулж байна.

Техник, технологийн хөгжихийн зэрэгцээ Монгол ахуй соёл гээгдэн үлдэх аюул тулгараад байна.

Аялал жуулчлалын салбар түүнийг таниулах мэдээ мэдээлэл хомс байна.

Иргэд хүүхэд залуусын монгол өв соёлын талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байгаа учир Монгол наадам, монгол өв соёлыг таниулан сурталчлах үйл ажиллагааг өргөн хүрээтэй зохион байгуулах шаардлагатай.

4.Техникийн хүчин зүйл (Т)

Монгол наадам цогцолборт эко шинэ дэвшилтэт технологи бүхий материаллаг баазыг бүрдүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Орчин үеийн шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх асуудал их хэмжээний хөрөнгө санхүүгийн эх үүсвэр шаарддаг нь зарим талаар шинэчлэлтийн үйл ажиллагаанд саад болж байна.

Дэлхий дахинд болон олон улсын түвшинд бий болсон шинжлэх ухаан, технологийн ололт амжилтыг олж авах, хэрэгжүүлэх бүх талын боломж хангагдаагүй, энэ талаар тусгайлсан хөтөлбөр, хөрөнгө оруулалт, дэмжлэг, тусламжийг төр, засгийн зүгээс үзүүлж чадахгүй байна.

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

“ Монгол наадам цогцолбор “ ОНӨТҮГ-ын орчны шинжилгээний үр дүнгээр цогцолбор нь “тогтворжилтын стратеги “-ийг баримтлах нь оновчтой байна.

Тогтворжилтын стратеги байгууллагын ерөнхий үйл ажиллагааны тогтворжилтод анхаарч , үйлчилгээний чанарыг сайжруулж, өсөж хөгжих , байр сууриа хадгалан төрөөс хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийг анхаарч ажиллахыг шаарддаг.

Иймд “ Монгол наадам цогцолбор “ ОНӨТҮГ-ын орчны шинжилгээний үр дүн тус байгууллагын цаашдын хөгжлийн стратегийг тодорхойлох үндэслэл болов.

Ингэхдээ Цогцолборын мандатын хүрээнд стратегийн зорилгыг тодорхойлсон.

Учир нь төрийн байгууллагын хувьд хуулиар олгогдсон чиг үүргээсээ давсан стратегийн зорилгыг тодорхойлсон тохиолдолд тухайн байгууллага уг стратегийн зорилгыг хэрэгжүүлэх боломж бүрдэхгүй юм.

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын 2023-2024 оны стратеги төлөвлөгөөний хүрээнд дараах стратегийн зорилгыг дэвшүүлэв.

Хүснэгт 6: Стратегийн зорилго

Стратегийн зорилго 1:	“Монгол наадам үндэсний спорт цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад байгууллагын үүргийн хүрээнд идэвх санаачлагатай ажиллана
Стратегийн зорилго 2:	Нийслэлийн иргэдэд зориулж “UB RESORT” цанын бааз байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлнэ
Стратегийн зорилго 3:	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орлогын бүрдүүлэлт, түүний эх үүсвэрийг өргөжүүлнэ
Стратегийн зорилго 4:	Зөв хандлага, бүтээмж өндөртэй хүний нөөцийг бүрдүүлнэ
Стратегийн зорилго 5:	Байгууллагын дотоод үйл ажиллагаа бүрэн уялдаатай болсон байна

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ ТҮВШИН, ЗОРИЛТОТ ТҮВШИН /Хүснэгт 7 /

Д Д	Стратегийн зорилго, зорилт	Стратег и	Шалгуур үзүүлэлт	Хэмж их нэгж	Шалгуур үзүүлэлтийн утга			
					Суур ь он	Суур ь түвш ин	Зорил тот он	Зорил тот түвш ин
1	Стратегийн зорилго 1. “Монгол наадам үндэсний спорт цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллагын үүргийн хүрээнд идэвхтэй ажиллана	Оролцогч талуудын хамтын ажиллагаа, мэдээллийн урсгалыг сайжруулах	Боловсруулагдсан саналын байдал	тоо	2022	3	2024	6
	1.1.Хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан цахилгаан хангамж,цэвэр ус хангамж,ариутгах татуургын төсвийг Улс,		Боловсруулагдсан саналын байдал	Тоо	2022	3	2024	6

	нийслэлийн төсөвт суулгуулахаар саналаа хүргүүлнэ.							
2	Стратегийн зорилго 2. Нийслэлийн иргэдэд зориулж “ UB RESORT” цанын бааз байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлнэ	Иргэдэд хүртээм жтэй үйлчилгээ бий болгох	Байгуулагдсан цанын бааз	тоо	2022	0	2024	1
	2.1.Цанын бааз байгуулах бэлтгэл ажлыг хангана.		Бэлтгэл ажил	хувь	2022		2024	100
	2.2.Цасны үйлдвэрлэх машин худалдан авах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх санал хүргүүлнэ.		Хүргүүлсэн саналын тоо	Тоо	2022	-	2024	1
	2.3.Цанын баазын үйл ажиллагааг эхлүүлж, жигдрүүлсэн байна.		Үйл ажиллагааны биелэлт	хувь	2022	-	2024	100
3	Стратегийн зорилго 3. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орлогын бүрдүүлэлт, түүний эх үүсвэрийг өргөжүүлнэ.	Мэдээллийн дэвшилтэт технологид тулгуурлах	Орлого бүрдүүлэлтийн хэмжээ, эх үүсвэрийн тоо	Мян.төг	2022	85,04	2024	100,06
	3.1.Байгууллагын зар сурталчилгааг сайжруулах, сувгийн тоог нэмэгдүүлнэ.		Зар сурталчилгаа	тоо	2022	0	2024	3
	3.2.Хамтран ажиллах байгууллага, иргэдийн тоог нэмэгдүүлэх		Хамтын ажиллагаатай иргэн, ААН, байгууллага	тоо	2022	8	2024	12
	3.4.Шинэ эвент арга хэмжээ, бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх		Бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлсэн байдал	тоо	2022	0	2024	2

4	Стратегийн зорилго 4. Зөв хандлага, бүтээмж өндөртэй хүний нөөцийг бүрдүүлнэ	Мэдлэг, ур чадвар, хандлагыг сайжруулах	Хүний нөөцийн чадавхын индекс	хувь	2022	0	2024	100
	4.1.Ажилтнуудын ажлын байрны шинжилгээ, албан тушаалын тодорхойлолтыг стратеги төлөвлөгөөнд үндэслэн боловсронгуй болгоно.		Стратеги төлөвлөгөөнд нийцүүлсэн албан тушаалын тодорхойлолт	тоо	2022	22	2024	26
	4.2.Зөв хандлага, бүтээмж өндөртэй ажилтнуудыг ажилд авах, сонгон шалгаруулах бүрэн чадамжтай болно		Туршилтын хугацааны ажлын гүйцэтгэлийн үнэлгээ	хувь	2022	70	2024	100
	4.3.Байгууллагын стратегийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварт албан хаагчдыг сургаж хөгжүүлнэ.		Байгууллагын сургалт хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт	хувь	2022	70	2024	90
5	Стратегийн зорилго 5. Байгууллагын дотоод үйл ажиллагаа бүрэн уялдаатай болсон байна	Хамтын ажиллагааг сайжруулах	Байгууллагын дотоод хамтын ажиллагаа, уялдааны чанарын индекс	хувь	2022	70	2024	90
	5.1.Байгууллагын чиг үүрэг, бүтцийн уялдааг оновчтой болгоно.		Чиг үүргийн уялдааны шинжилгээ	тоо	2022	0	2024	2
	5.2.Байгууллага, ажилтны гүйцэтгэлийн төлөвлөгөөний уялдааг бүрэн хангана.		Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	хувь	2022	90	2024	100


НАЙМ.СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА БҮТЦИЙН УЯЛДАА

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 99 дүгээр тогтоолыг үндэслэн Нийслэлийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/156 дугаар захирамжаар “Монгол Наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын байгууллагын бүтэц, орон тооны хязгаарыг 39 орон тоотойгоор батлав.


Хүснэгт 8: Бүтэц, орон тоо

	“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ	Батлагдсан бүтэц орон тоо
1.	Албаны тоо	4
	Нийт ажилтны тоо	39

Зураг 1. Ажилтны хүйсийн харьцааны диаграм




Зураг 2. Ажилтны насны ангилалын диаграм



МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ОНӨТҮГ -ЫН ОРОН ТООНЫ ХЯЗГААР

Зураг 3. Бүтцийн зураглал



Стратеги зорилго, байгууллагын бүтцийн уялдаа / Хүснэгт 9 /

Стратеги зорилго	Хэрэгжилтийг хариуцах бүтцийн нэгж
Стратегийн зорилго 1: “Монгол наадам үндэсний спорт цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад байгууллагын үүргийн хүрээнд идэвх санаачлагатай ажиллана.	Захиргаа, удирдлагын алба, Маркетинг хамтын ажиллагааны алба
Стратегийн зорилго 2: Нийслэлийн иргэдэд зориулж “ UB RESORT “ цанын бааз байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлнэ	Захиргаа, удирдлагын алба, Маркетинг хамтын ажиллагааны алба,Тохижилт үйлчилгээний алба
Стратегийн зорилго 3: Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орлогын бүрдүүлэлт, түүний эх үүсвэрийг өргөжүүлнэ.	Маркетинг хамтын ажиллагааны алба,Санхүү хөрөнгө оруулалтын алба
Стратегийн зорилго 4: Зөв хандлага, бүтээмж өндөртэй хүний нөөцийг бүрдүүлнэ.	Захиргаа удирдлагын алба
Стратегийн зорилго 5: Байгууллагын дотоод үйл ажиллагаа бүрэн уялдаатай болсон байна	Захиргаа удирдлагын алба

ЕС. “МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ-ЫН СТРАТЕГИЙН ЗУРАГЛАЛ /2023-2024 Хүснэгт 10.

Алсын хараа	Монгол улсад тив, дэлхийн чанартай спортын тэмцээн, уралдаан зохион байгуулах олон улсын жишиг, стандартад нийцсэн соёл, спорт, амралт, аялал жуулчлалын цогцолбор болно.				
	Уриа: Монгол наадам-Дэлхийн өв				
Эрхэм зорилго	Нүүдлийн соёл иргэншил, монголчуудын уламжлалт ёс заншил, үндэсний их баяр наадмыг сурталчлах, спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулах, иргэд олон нийтийг ая тухтай амрах, чөлөөт цагаа таатай өнгөрүүлэх орчныг бүрдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх				
	Үнэт зүйл: Монгол ахуй ба Монгол наадам Уламжлалт зан заншил Эко хөгжил болон ногоон бүс Чанар, ил тод хариуцлагатай байдал Шинэ бүтээлч сэтгэлгээ				
Стратеги йн зорилго	Стратегийн зорилго 1. “Монгол наадам үндэсний спорт цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад	Стратегийн зорилго 2. Нийслэлийн иргэдэд зориулж “ UB RESORT “ цанын бааз байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлнэ.	Стратегийн зорилго 3. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орлогын бүрдүүлэлт, түүний эх үүсвэрийг өргөжүүлнэ.	Стратегийн зорилго 4. Зөв хандлага, бүтээмж өндөртэй хүний нөөцийг бүрдүүлнэ.	Стратегийн зорилго 5. Байгууллагын дотоод үйл ажиллагаа бүрэн уялдаатай болсон байна.

	байгууллагын үүргийн хүрээнд идэвхтэй ажиллах				
Стратеги	Оролцогч талуудын хамтын ажиллагаа, мэдээллийн урсгалыг сайжруулах	Иргэдэд хүртээмжтэй үйлчилгээ бий болгох	Мэдээллийн дэвшилтэт технологид тулгуурлах	Мэдлэг, ур чадвар, хандлагыг сайжруулах	Хамтын ажиллагааг сайжруулах
Стратегийн зорилт	1.1.Хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан цахилгаан хангамж, цэвэр ус хангамж, ариутгах татуургын төсвийг Улс, нийслэлийн төсөвт суулгуулахаар саналаа хүргүүлнэ.	2.1.Цанын бааз байгуулах бэлтгэл ажлыг хангана. 2.2.Цас үйлдвэрлэх машин худалдан авах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх санал хүргүүлнэ 2.3.Цанын баазын үйл ажиллагааг эхлүүлж, жигдрүүлсэн байна.	3.1.Байгууллагын зар сурталчилгааг сайжруулах, сувгийн тоог нэмэгдүүлнэ. 3.2.Хамтран ажиллах байгууллага, иргэдийн тоог нэмэгдүүлэх 3.4.Шинэ эвент арга хэмжээ, бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх	4.1.Ажилтнуудын ажлын байрны шинжилгээ, албан тушаалын тодорхойлолтыг стратеги төлөвлөгөөнд үндэслэн боловсронгуй болгоно. 4.2.Зөв хандлага, бүтээмж өндөртэй ажилтнуудыг ажилд авах, сонгон шалгаруулах бүрэн чадамжтай болно. 4.3.Байгууллагын стратегийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварт албан хаагчдыг сургаж хөгжүүлнэ.	5.1.Байгууллагын чиг үүрэг, бүтцийн уялдааг оновчтой болгоно. 5.2.Байгууллага, ажилтны гүйцэтгэлийн төлөвлөгөөний уялдааг бүрэн хангана. 5.3.Байгууллагын хамтач соёлыг төлөвшүүлнэ.
Хариуцах нэгж	Захиргаа удирдлагын алба Маркетинг,хамтын ажиллагааны алба	Захиргаа удирдлагын алба Маркетинг,хамтын ажиллагааны алба	Маркетинг,хамтын ажиллагааны алба Санхүү, хөрөнгө	Захиргаа удирдлагын алба	Захиргаа удирдлагын алба

		Тохижилт, бүтээн байгуулалтын алба	оруулалтын алба		
--	--	---	--------------------	--	--

